



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/19

Баян-Өндөр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337, 2023 оны А/451, 2024 оны А/424 дүгээр тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Сувилахуйн эмнэл зүйн ур чадварын шатлал (Клиник ладерь)-ыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай
2. Сувилахуйн цогц чадамжид нийцүүлэн ажлын төлөвлөгөөг батлуулан, зохион байгуулан арга зүйгээр ханган ажиллахыг Сувилахуй болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д даалгасугай.

ДАРГА



Ц МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 02 дугаар
сарын 27 өдрийн 419 дугаар тушаалын
нэгдүгээр хэсрэлт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:

Эрүүл мэндийн газрын Сувилахуй болон
хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн Г.Энхзаяа

Нарийн бичиг:

Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний
дэд төвийн Сувилахуйн албаны дарга
А.Булганчимэг

Гишүүд:

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
Арга зүйч Т.Энхжин

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
Сувилахуйн албаны дарга С.Хажидмаа

Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн
сувилагч Ч.Тунгалаг

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
Ахлах сувилагч М.Нямсүрэн

Эрдэнэт сувиллын цогцолборын Ахлах
сувилагч Г.Нарангэрэл

Хойд бүсийн хавдрын оношилгоо,
эмчилгээний дэд төвийн Арга зүйч
М.Лхамсүрэн

Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн
Ахлах сувилагч Б.Амгаланхүү

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн
Ахлах сувилагч Т.Одонтунгалаг

“Талын булаг” эмнэлгийн Ахлах сувилагч
Ч.Хосбаяр

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 27 өдрийн А/451... дугаар тушаалын хоёрдугаар хавсгалт



**СУВИЛАХУЙН ЭМНЭЛ ЗҮЙН УР ЧАДВАРЫН ШАТЛАЛ
/КЛИНИК ЛАДЕРЬ/ -ЫН УДИРДАМЖ**

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Эрүүл мэндийн Яам болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран “Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг 2021 оны 01 дүгээр сараас эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд сувилахуйн цогц чадамжийг боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Сувилагч, эх баригчийн цогц чадамж” А/451 тоот тушаал батлагдсан. Энэхүү цогц чадамжийг хэрэгжүүлэхэд сувилагч, тусгай мэргэжилтний эмнэл зүйн ур чадварыг үе шаттайгаар хөгжүүлж, тэдний ажлын ачаалал, мэргэжлийн үнэ цэнийг таниулах цаашлаад нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг аюулгүй чанартай үзүүлэх нь маш чухал юм.

Цаашид сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор цогц чадамжид суурилан сувилагч мэргэжилтнийг хөгжүүлэхэд сувилахуйн эмнэл зүйн ур чадварыг үе шаттай үнэлэх шалгуур хуудас боловсруулж, үнэлэгээг аймгийн хэмжээнд зохион байгуулна.

ЗОРИЛГО:

Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй үзүүлэх цогц чадамж бүхий сувилагч, тусгай мэргэжилтэнг бэлтгэх

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА:

- Эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуйн зөвлөл
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Өрхийн эрүүл мэндийн төв-8
- Жаргалант сумын эрүүл мэндийн төв
- Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв
- Эрдэнэт сувиллын цогцолбор
- Хувийн хэвшлийн ор бүхий клиникүүд, оргүй клиникүүдийн “Чандмань эрдэнэ” холбоо

ХУГАЦАА: 2026 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ныг хүртэл

АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ажлын хэсгийн нэгдсэн уулзалт, хурлыг зохион байгуулах	Сар бүр	Нарийн бичгийн дарга
2	Сувилахуйн эмнэл зүйн ур чадварыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулах	2026 оны 03 сар	Ажлын хэсгийн гишүүд

3	Эрүүл мэндийн байгууллагуудын ахлах сувилагч нарт "Сувилахуйн эмнэл зүйн ур чадварын шатлал" сургалт зохион байгуулах	2026 оны 03,04 сар	Ажлын хэсгийн гишүүд
4	Зөвлөх мэргэжилтнээс зөвлөгөө авах, сургалт зохион байгуулах	2026 оны 03, 06,09 сар	Ажлын хэсгийн гишүүд
5	Хэлэлцүүлэг зохион байгуулж зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах	2026 оны 04,06 сар	Ажлын хэсгийн гишүүд
6	Эмнэл зүйн ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх үнэлгээний хуудсыг Эрүүл мэндийн газрын Сувилахуйн зөвлөл, Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах	2026 оны 10 сар	Ажлын хэсгийн гишүүд

ХҮЛЭЭГДЭЖ БУИ ҮР ДҮН:

1. Аймгийн хэмжээнд сувилахуйн эмнэл зүйн ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх үнэлгээний шалгуур хуудас гарсан байна.
2. Сувилагч, тусгай мэргэжилтэн бүр эмнэл зүйн ур чадварын шатлалыг ойлгосон, өөрийг хөгжүүлэхэд анхаарч эхлэнэ.
3. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар сайжирна